

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Байгууллагын байнгын хяналтанд авч хүмүүсийг оруулж гаргахдаа анхаарч, ажил үүргээ туйлын сонор сэрэмжтэй шудрага үнэнчээр биелүүлэх Завхан аймгийн Татварын газрын 500 мкв талбай бүхий албан конторын барилга, 400 мкв гадна талбай, хашаанд 24 цагийн харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх.

Харуул хамгаалалтын үйлчилгээ харуул хамгаалалтын үйлчилгээний хамрах хүрээ, чиг үүрэг:

1. Харуул хамгаалалтын компани нь Завхан аймгийн Улиастай сумын Жинс багт байрлах Татварын газрын конторын барилга бүхий 2 давхар 500мкв талбай бүхий объект, нийтийн эдэлбэрээс бусад манай байгууллагын гадна талбай, хашаа, өмч, хөрөнгөд 24 цагийн харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлнэ.
2. Харуул хамгаалалтын компанийн харуул хамгаалалтын ажилтан нь “Үндэсний ажил мэргэжил , албан тушаалын жагсаалт, ангилал, тодорхойлолт батлах тухай “ 2010 оны 16 дугаар тушаалаар батлагдсан жагсаалт дахь 5414 кодтой “Хамгаалалтын албаны ажилтан”-ы тодорхойлолт, гүйцэтгэх чиг үүрэгт дурьдсан болон доорхи үйлчилгээг үзүүлж ажиллана.Үүнд:
  - 2.1 Хамгаалах объектын өмч хөрөнгийг хулгайлах, хорлон сүйтгэх явдлаас хамгаалж, байгууллагад орох гарах хэсгийг хяналтандаа байлгаж, байгууллагын гадна, дотно аюулгүй байдлын талаарх нийтэд хамаарах дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах,
  - 2.2 Хамгаалах объектод завшөөрөлгүй нэвтрэн орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор, цонх хаалгыг шалгаж, эргэж , тойрч байх,
  - 2.3 Хамгаалах объектод нэвтрэх дотоод ажилтаны болон гадны хүний бичиг баримтыг шалгах, гарч , орж ирж байгаа хүмүүст хяналт тавих,
  - 2.4 Дэг журмыг сахиулах, гадна дотны аливаа эрсдэлт үйлдлээс байгууллагын эд хөрөнгийг хамгаалах, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулахын тулд гадны зочид, иргэдэд шаардлага тавих,
  - 2.5 Хамгаалах объектод үүсэх гал түймрийн болон ус, дулаан алдах гэх мэт аюул гарвал цаг алдалгүй Цагдаа, Онцгой байдал болон холбогдох бусад байгууллагуудад мэдэгдэх,
3. Монгол улсын Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүнийн нууцын тухай хуулийг мөрдөж ажиллана.
4. Харуулын объектод байрлах хяналтын камеруудыг ашиглах.
5. Компанийн шинэчлэсэн дүрэмтэй байхаас гадна өөрийгөө санхүүжүүлэх чадвартай байна.
6. Харуул хамгаалалтын үйлчилгээг гүйцэтгэгч нь хамгаалалтын ажиллагсдын хувцас хэрэглэл, хоол, унаа, хамгаалах хэрэгсэл, даатгалтай холбоотой зардлуудыг бүрэн хариуцна.